



УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

2023 оны Завхан аймгийн агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогын тайлан

ЗАВХАН АЙМАГ

2024 ОН

**ЗАВХАН АЙМГИЙН АГААРЫН БОХИРДЛЫН ЭХ ҮҮСВЭРИЙН УЛСЫН
НЭГДСЭН ТОО БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН**

2024-01-25

Улиастай

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

“Агаарын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэхь заалт, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг үндэслэн, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай” 2023/410 албан тоот, Аймгийн засаг даргын “Ажлын хэсэг томилох тухай” А/435 захирамж, Аймгийн засаг даргын Тамгын газрын даргын “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах тухай” З/1009 албан тоотын дагуу уг ажлыг зохион байгуулав.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторийн ажилчид 24 сумын агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг хийж гүйцэтгэх ажлын хэсэгт орсон албан хаагч нарт арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгч тооллолгыг хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх ажлын үндсэн зорилго нь Монгол улсын “Агаарын тухай хууль”, “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, аймаг, нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн төрөл, тоо хэмжээг тогтоож бүртгэлд хамруулах, тэдгээрийн талаарх мэдээ мэдээллийн төрөлжсөн санг бий болгох, агаарын бохирдлын эх үүсвэрээс гарах хорт хаягдлыг хянах, агаарын чанарын төлөв байдлыг урьдчилан мэдээлэх, агаарын бохирдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бууруулах, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндийг хамгаалах зэргээр төлөвлөлт хийх, бодлого, хөтөлбөр боловсруулах, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход шаардлагатай тулгуур суурь мэдээлэл бүрдүүлэхэд оршино.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг сумдын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулан, тооллогын мэдээллийг нэгтгэн боловсруулан тайланг хүргүүлж байна.

Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 24 суманд 2023 оны 11 дүгээр сарын 15-аас 2024 оны 01 сарын 15-н хүртэл хийж гүйцэтгэлээ.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журмын дагуу тоо бүртгэлд агаарын бохирдлын доорхи эх үүсвэрүүдийг хамруулан тоолсон.

1. Агаарын бохирдлын суурин эх үүсвэр / журмын хавсралт 1-3, 5-7 дугаар маягт/ Үүнд:
 - 3-15кВт хүртэлх хүчин чадалтай зуух: / Айл өрхийн ахуйн хэрэглээ, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уламжлалт болон сайжруулсан зуух, пийшин, усан халаалтын зуух/
 - 15-100кВт хүртэл хүчин чадалтай зуух: / Ахуйн хэрэглээний усан халаалтын зуух, төвлөрсөн дулаан хангамжийн системийн усан халаалтын зуух/
 - 100-4200кВт-аас дээш хүчин чадалтай зуух: /Технологийн зориулалттай зуух, төвлөрсөн дулаан хангамжийн системийн халаалтын зуух/
2. Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр

➤ Агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрт дизель түлш болон шатахуунаар ажилладаг бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл, өөрөө явагч болон зөөврийн хөдөлгөөнт хэрэгслийг хамруулах ба энэ журмын хавсралт 5 дугаар маягтын дагуу улсын тоо бүртгэлийг хийнэ.

Аймгийн 2023 оны нэгдсэн тоо, бүртгэлийн дүнгээр агаар бохирдуулагч суурин эх үүсвэр нийт 10753 бүртгэгдсэн. Үүнд: Галлагаатай өрх, төвлөрсөн халаалтад холбогдоогүй 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг 10639 айл өрх, аж ахуй нэгж, 15-100 кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг 70 аж ахуй нэгж, 100-4200 кВт хүчин чадалтай зуух 44 тоологдсон ба аймгийн хэмжээнд нийт **92374.5м³** мод, **49273.25 тн** нүүрс, **153.825 тн** сайжруулсан түлш, бусад **3059.2 тн** түлш хэрэглэсэн байна. Хөдөлгөөнт эх үүсвэр **13429** тоологдсон.

ХОЁР. СУУРИН ЭХ ҮҮСВЭРИЙН ТОО БҮРТГЭЛ

2.1. Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуухны тооллогын дүн

Ердийн галлагаатай 3-15 кВт хүртэлх хүчин чадалтай зуух. Үүнд: Айл өрхийн ахуйн хэрэглээ, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уламжлалт болон сайжруулсан зуух, пийшин, усан халаалтын зуух орно.

№	Сумд	Айл өрхийн зуух					
		Гэр	Байшин	Түлшний хэмжээ			
				Нүүрс, тн	Мод, м ³	Сайжруулсан түлш, тн	Бусад, тн
1	Алдархаан	50	28	27	508	-	23.5
2	Асгат	79	72	-	2770	-	-
3	Баян тэс	178	153	-	3115	-	-
4	Баянхайрхан	108	67	-	1774	-	-
5	Дөрвөлжин	157	73	367.4	1016.5	-	-
6	Завхан мандал	78	61	155.5	165	-	-
7	Их уул	279	418	38.5	9782	-	32
8	Идэр	121	190	28.5	4464	-	-
9	Нөмрөг	100	152	78	2707	-	-
10	Отгон	178	106	598.1	67	-	971.9
11	Сантмаргац	122	98	103.5	1728	-	890
12	Сонгино	102	138	38.5	1840	-	-
13	Түдэвтэй	100	129	120.4	2570	-	-
14	Тэс	84	261	21.2	2434	-	1.0
15	Тэлмэн	91	153	66.8	1218	-	-
16	Тосонцэнгэл	441	1155	270.7	23087	-	-
17	Улиастай	2457	1766	2650.7	27707.4	153.825	262.9
18	Ургамал	78	53	324.8	491	-	-
19	Цагаанхайрхан	34	24	47.8	376	-	66.6
20	Цагаанчулуут	94	27	131.5	500	-	57.9
21	Цэцэн уул	47	115	8	1817	-	-
22	Шилүүстэй	112	77	416.9	104.6	-	531.9
23	Эрдэнэхайрхан	85	49	46.5	574	-	221.5
24	Яруу	55	44	24.5	1036	-	-
Аймгийн хэмжээнд		5230	5409	5564.8	91851.5	153.825	3059.2

Хүснэгт 1. Ердийн галлагаатай зуухны тоо, түлшний хэмжээ

2023 онд Завхан аймгийн хэмжээнд нийт агаар бохирдуулагч 10639 айл өрх, 5564.8тн нүүрс, 91851.5м³ мод, 153.825тн сайжруулсан түлш, 3059.2тн бусад түлш зарцуулсан байна.

Он	Зуухны тоо		Нийт
	Ердийн	Сайжруулсан	
2016 он	11168	63	11231
2017 он	10962	40	11002
2018 он	10800	120	10920
2019 он	10121	444	10565
2020 он	10195	374	10569
2021 он	9418	592	10010
2022 он	10009	545	10554
2023 он	9905	734	10639

Хүснэгт 2. Ердийн галлагаатай зуухны төрөл, тоогоор /сүүлийн 7 жилээр/




График 1. Ердийн зуухны тоо

График 2. Сайжруулсан зуухны тоо

Он	Нэгж	Нүүрс /тн/	Сайжруулсан түлш /тн/	Мод /м ³ /	Бусад /тн/
2016	Түлшний хэмжээ тн/жил, м ³	1834.6	-	102632	662.5
2017		1933.8	-	105400	591.5
2018		4982.3	20.0	103176	1997.8
2019		6773.5	222.9	96683.9	2729.2
2020		5939.4	1141.8	93012	2424.2
2021		6086.7	225.75	87595.2	1398.7
2022		6626.7	184.0	94428.1	3065.2
2023		5564.8	153.825	91851.5	3059.2

Хүснэгт 3. 3-15кВт хүчин чадалтай зуухны түлшний хэмжээ

Завхан аймгийн 24 сумын айл өрхүүд нь ихэвчлэн мод хэрэглэдэг ба өмнөх онтой харьцуулан харахад 2.7% буурсан, нүүрсний хэрэглээ мөн буурсан харагдаж байна.

2.2. Усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай зуухны тооллогын дүн

Аймгийн хэмжээнд усан халаалтын 15-100 кВт-ын хүчин чадалтай 70 зуух тоологдон 4866.65тн нүүрс, 523м³ мод зарцуулж дулаан үйлдвэрлэсэн байна. Ахуйн хэрэглээнд ашиглагдаж байгаа уурын болон усан халаалтын зуух, технологийн зориулалттай уур үйлдвэрлэдэг зуух, төвлөрсөн болон нэгдсэн дулаан хангамжийн усан халаалтын зуух, барилгын болон томоохон үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж байгаа зуухнууд орно. Үүнд:

№	Сумын нэр	Усан халаалтын зуух /15-100кВт/		
		Зуухны тоо	Түлшний хэмжээ	
			Нүүрс/тн/	Мод/м ³ /
1	Улиастай	25	3923.65	-
2	Алдархаан	1	120	-
3	Сонгино	1	30	-
4	Тэс	2	361	120
5	Тэлмэн	3	22	28
6	Тосонцэнгэл	38	410	375
Аймгийн хэмжээнд		70	4866.65	523

Хүснэгт 4. Усан халаалтын болон уурын зуухны тоо

2016-2022 оны усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай зуухны тооллогын дүнг харьцуулахад: /Аймгийн хэмжээнд/



График3. 15-100кВт-ын хүчин чадалтай зуухны тоо

Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр 2023 онд Тосонцэнгэл 7 зуух шинээр нэмж тоологдсон ба Улиастай сумд 8 зуух хасагдсан. Үүний 1 зуух цахилгаан, 1 зуух төвлөрсөн халаалтанд, 2 зуух нэгдэж, 4 зуухны үйл ажиллагаа зогссон. Их уул 9, Отгон 8 зуух 101-4200кВт төвлөрсөн халаалтанд холбогдсон байна.

2.3 101- 4200 кВт хүчин чадалтай зуухны тооллогын дүн

Аймгийн хэмжээнд 44 зуух 100- 4200кВт хүчин чадалтай зуух ашиглаж нийт 38842тн нүүрс зарцуулан дулаан үйлдвэрлэж байна.

№	Сумд	Уурын болон усан халаалтын зуух /100-4200кВт/	
		Зуухны тоо /ш/	Нүүрс /тн/
1	Улиастай	16	17970
2	Алдархаан	1	750
3	Асгат	1	350
4	Баянтэс	1	1100
5	Баянхайрхан	1	500
6	Дөрвөлжин	3	5205
7	Завханмандал	1	800
8	Их уул	1	800
9	Идэр	1	363
10	Нөмрөг	1	700
11	Отгон	1	720
12	Сантмаргаз	1	900
13	Сонгино	1	484
14	Түдэвтэй	1	800
15	Тэс	1	1100
16	Тэлмэн	1	1380
17	Тосонцэнгэл	4	1380
18	Ургамал	1	700
19	Цагаанхайрхан	1	310
20	Цагаанчулуут	1	450
21	Цэцэн уул	1	120
22	Шилүүстэй	1	580
23	Эрдэнэхайрхан	1	280
24	Яруу	1	1100
Нийт		44	38842

Хүснэгт 5. 100-4200кВт-ын зуухны тоо, түлшний хэмжээ /жилээр/

ГУРАВ. ХӨДӨЛГӨӨНТ ЭХ ҮҮСВЭРИЙН ТОО БҮРТГЭЛ

2023 оны агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр аймгийн хэмжээнд нийт 13429 авто тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Өмнөх онтой харьцуулахад тусгай зориулалт, нийтийн тээвэрийн тоо буурч, бусад төрлийн тээврийн хэрэгслийн тоо өсөлттэй байна.


Үзлэгт орсон авто тээврийн хэрэгслийг сум тус бүрээр дараах хүснэгтэд харуулав.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо

№	Сумдын нэр	Зориулалт							Нийт
		Суудал	Ачаа	Мотоцикл	Нийтийн тээвэр	Тусгай зориулалт	Цистерн	Зүтгүүр	
1	Алдархаан	284	263	68					615
2	Асгат	76	43	24		14	1		158
3	Баян тэс	183	81	58					322
4	Баянхайрхан	73	57	145		1			276
5	Дөрвөлжин	138	68	2	13	6			227
6	Завханмандал	107	66	120					293
7	Их уул	433	477		22	18			950
8	Идэр	236	78	76	1	3			394
9	Нөмрөг	181	179	328					688
10	Отгон	125	110	114					349
11	Сантмаргац	100	65	98		1	1		265
12	Сонгино	172	99	75		2	1	1	350
13	Түдэвтэй	72	80	165					317
14	Тэс	230	70	56					356
15	Тэлмэн	285	208	42		1			536
16	Тосонцэнгэл	1059	141	952	8	3	3		2166
17	Ургамал	149	73			2			224
18	Улиастай	2088	616	17	103	19	22	9	2874
19	Цагаанхайрхан	73	19	31					123
20	Цагаанчулуут	64	97	12		1			174
21	Цэцэн уул	60	38	102					200
22	Шилүүстэй	98	75	408		1	1		583
23	Эрдэнэхайрхан	298	111	86	6		1		502
24	Яруу	129	193	165					487
Аймгийн хэмжээнд		6713	3307	3144	153	72	30	10	13429

Хүснэгт 6. Хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо

Нийт тээврийн хэрэгслийг түлшний төрлөөр ангилан авч үзвэл бензин болон дизель хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн харьцангуй ихээр хэрэглэж байгаа ба насжилтаар ангилан авч үзэхэд 10 ба түүнээс дээш жил хэрэглэж буй тээврийн хэрэгслийн тооны өсөлт бусдаасаа харьцангуй их байгаа нь хүн амын амьжиргааны түвшнээс хамааран насжилт өндөртэй хямд өртөгтэй тээврийн хэрэгслээр хэрэгцээгээ хангаж байна.



Зураг1. Хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо

ДӨРӨВ. АГААР БОХИРДУУЛАХ БОДИСЫН ХАЯГДЛЫН ТООЛЛОГО


Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны А/600 тушаалаар аргачлал батлагдан гарсан. Энэхүү аргачлалыг ашиглан үндэсний хэмжээнд агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллогыг хийж хаягдлын хэмжээг бодитой тодорхойлсноор Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх үндэслэл болохын зэрэгцээ Завхан аймгийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэхэд ашиглах боломжтой шинжлэх ухааны үндэслэлтэй бодит тооцооллын дүн бий болох юм.

Агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого хийх гол зорилго нь аймаг, сумын агаарын бохирдлын эх үүсвэрийн мэдээлэл, тоон өгөгдлийг ашиглан агаар бохирдуулах бодисын хаягдлын тооллого хийж, бодит тоон хэмжээг тодорхойлоход оршино.

24 сумын 3-15кВт хүртэл хүчин чадалтай 10639 айл өрх, аж ахуй нэгж, 15-100кВт хүртэл хүчин чадалтай зуух ашигладаг 70 аж ахуй нэгж, 101-4200кВт хүчин чадалтай зуух 44 тоологдсон ба аймгийн хэмжээнд нийт 10753 зуух 92374.5м³ мод, 49273.25тн нүүрс, 153.825тн сайжруулсан түлш, бусад 3059.2тн түлш хэрэглэн хичнээн хэмжээний хаягдал агаарт хаягдаж буйг тооцон дараах хүснэгтээр харуулав.

№	Сумдын нэр	Тоо	SO ₂ /тн/	NO _x /тн/	TSP /тн/	PM10 /тн/	PM2.5 /тн/	CO /тн/
1	Улиастай	4267	276.3358069	155.2222526	821.2823501	778.7436413	732.5962708	3127.591317
2	Алдархаан	80	7.89239625	1.84098375	9.80038875	9.304261875	8.484193125	42.35763188
3	Асгат	152	5.111625	3.125375	12.361875	11.7474375	11.2040625	60.9649375
4	Баянтэс	332	11.8021875	4.5813125	19.9130625	18.92540625	17.70684375	94.77990625
5	Баянхайрхан	176	4.5139	2.00486875	22.07673125	20.972125	19.2119	43.93838125
6	Дөрвөлжин	233	40.54039925	6.56393875	112.1498858	106.4005534	95.71855963	210.6531734
7	Завханмандал	140	7.4980725	1.4975025	8.6242125	8.13461875	7.43218125	42.11428875
8	Их уул	698	14.51160125	10.48695375	40.62723875	38.58752438	37.03568063	202.9996044
9	Идэр	312	6.317514	4.655115	19.062801	18.106047	17.337927	87.592617
10	Нөмрөг	253	6.7400475	3.0630125	32.4124025	30.75323625	28.26937375	70.04273625
11	Отгон	285	10.30443575	4.26554525	20.38672025	19.13746113	18.27172988	112.3750331
12	Сантмаргаз	221	11.2946525	5.4176325	22.9617425	21.77523875	20.62966125	113.2641088
13	Сонгино	242	5.9358	3.9308075	15.9791775	15.16904125	14.43553875	79.12895125
14	Түдэвтэй	230	7.407353	3.052739	35.416263	33.5938635	30.8009885	72.9700555
15	Тэс	348	11.855714	3.667602	47.097584	44.732018	40.685088	87.123754
16	Тэлмэн	248	13.218511	3.331033	16.763861	15.9012845	14.5918795	77.6869285
17	Тосонцэнгэл	1638	28.079819	24.418932	106.300824	100.5777055	96.1333005	461.1428515
18	Ургамал	132	7.4517235	1.8200925	10.1075065	9.48211425	8.83715175	54.54917425
19	Цагаанхайрхан	59	2.54522725	0.77954475	12.27158175	11.63729038	10.59279663	20.87554838
20	Цагаанчулуут	122	4.7992275	1.4314375	7.0389675	6.64202125	6.19693875	36.35295125
21	Цэцэн уул	163	2.4404225	1.8908675	7.2455975	6.88163875	6.61945125	36.41137875
22	Шилүүстэй	190	6.267263	2.253868	27.481084	25.9353355	23.9331505	68.6752695
23	Эрдэнэхайрхан	135	3.47027625	1.58396875	6.86715375	6.505336875	6.159388125	34.03965688
24	Яруу	100	7.81229	1.734195	39.091815	37.12198	33.50033	48.40629

Хүснэгт 7. Завхан аймгийн хэмжээнд зуухнуудаас ялгарч агаарт хаягдаж буй хаягдлын хэмжээ



Зураг 2. Суурин эх үүсвэрийн нийт бохирдуулах бодисын хаягдлын хэмжээ

2023 оны Агаарын бохирдлын эх үүсвэрийн Улиастай сумын ААНБ-ын тооллогын мэдээгээр бохирдлын хаягдлыг тооцсон үр дүн:

ААНБ	Он	SO ₂ /тн/	NO _x /тн/	TSP /тн/	PM10 /тн/	PM2.5 /тн/	CO /тн/	Нийт /тн/
Нам даралт зуух /100-4200 кВт/	2023	285.5	42.9	670.5	637.1	569.9	1186.5	<u>3392.4</u>
Нам даралтын зуух /15-100 кВт/		42.3	9.8	52.5	49.1	44.1	152.5	<u>350.3</u>
3-15 кВт хүчин чадалтай зуух		176.4	199.9	750.2	710.6	692.4	3947	<u>6476.5</u>




График 4. 101-4200 кВт-ын зуухны ялгарал тооцсон харьцуулалт / 2019-2023/

101-4200кВт хүчин чадалтай зуухны хаягдлын тооцооллыг өмнөх онтой харьцуулахад өссөн байна.





График 5. 15-100кВт хүчин чадалтай зуухны хаягдлын тооцоо /2019-2023 он/


15-100кВт хүчин чадалтай зуухны хаягдлын тооцооллыг өмнөх онтой харьцуулахад өссөн байна.

Завхан аймгийн хэмжээн дэх нийт хаягдлын хэмжээ тус бүрээр arcgis программ ашиглан тархалтын зургийг зураглан харуулав.




Зураг 3. 3-15кВт хүчин чадалтай зуухны бохирдуулах бодисын хаягдлын хэмжээ

3-15кВт-ын хүчин чадалтай зуухнаас ялгарч агаар бохирдуулж буй бохирдуулах бодисын хаягдлын хэмжээгээр Улиастай сумд их хэмжээгээр хаяж байгаа харагдаж байна.



Зураг 4. 15-100кВт хүчин чадалтай зуухны бохирдуулах бодисын хаягдлын хэмжээ

15-100кВт-ын хүчин чадалтай зуухнаас ялгарч агаар бохирдуулж буй бохирдуулах бодисын хаягдлын хэмжээгээр Улиастай сумд их хэмжээгээр хаяж байна.



Зураг 5. 100-4200кВт хүчин чадалтай зуухны бохирдуулах бодисын хаягдлын хэмжээ

100-4200кВт-ын хүчин чадалтай зуухнаас ялгарч агаар бохирдуулж буй бохирдуулах бодисын хаягдлын хэмжээгээр Улиастай, Дөрвөлжин сумд их хэмжээгээр хаяж байна.


ТАВ. ХОГ ХАЯГДЛЫН ЦЭГИЙН ТОО БҮРТГЭЛ

Хүн амын нягтшил, төлөвлөлтөөс шалтгаалан хогийн цэгийн талбай тооцогддог ба үүнтэй холбоотойгоор гарч буй хаягдлын хэмжээ ялгаатай харагдаж байна.

№	Сумдын нэрс	Хог хаягдлын хэмжээ, /тн/	NMVOС /тн/	TSP /тн/	PM10 /тн/	PM2.5 /тн/
1	Цагаанхайрхан	535	0.00065805	0.002482	0.002413	0.002242
2	Баянхайрхан	271	0.000333	0.001257	0.001222	0.001135
3	Түдэвтэй	677	0.00083271	0.003141	0.003053	0.002837
4	Тэлмэн	462	0.00056826	0.002144	0.002084	0.001936
5	Эрдэнэхайрхан	327.492	0.00040221	0.001517	0.001475	0.00137
6	Ургамал	281	0.00034563	0.001304	0.001267	0.001177
7	Тэс	120	0.0001476	0.000557	0.000541	0.000503
8	Яруу	170	0.0002091	0.000789	0.000767	0.000712
9	Алдархаан	462	0.000568	0.002144	0.002084	0.001936
10	Завханмандал	788	0.000969	0.003656	0.003554	0.003302

11	Шилүүстэй	230	0.0002829	0.001067	0.001037	0.000964
12	Нөмрөг	663	0.000815	0.003076	0.00299	0.002778
13	Дөрвөлжин	500	0.000615	0.00232	0.002255	0.002095
14	Асгат	800	0.000984	0.003712	0.003608	0.003352
15	Идэр	545	0.00067	0.002529	0.002458	0.002284
16	Сонгино	227.04	0.00027921	0.001053	0.001024	0.000951
17	Отгон	685	0.000843	0.003178	0.003089	0.00287
18	Цагаанчулуут	500	0.000615	0.00232	0.002255	0.002095
19	Цэцэн-Уул	365	0.00044895	0.001694	0.001646	0.001529
20	Сантмаргаз	68	0.00008364	0.000316	0.000307	0.000285
21	Их-Уул	123	0.000151	0.000571	0.000555	0.000515
22	Тосонцэнгэл	1500	0.001845	0.00696	0.006765	0.006285
23	Баянтэс	265.4	0.000326	0.001231	0.001197	0.001112
24	Улиастай	15114	0.01859	0.070129	0.068164	0.063328

Хүснэгт 8. Завхан аймгийн 24 сумын хог хаягдлын хэмжээ



Зураг 6. Хатуу хог хаягдлаас ялгарч агаарт хаягдах хаягдлын тархалтын зураг

Аймгийн хэмжээнд жилд хаягдсан хог хаягдлаас ялгарч агаарт хаягдах хаягдлын тархалтаас харахад Улиастай, Тосонцэнгэл сумдын хувьд хаягдлын хэмжээ их харагдаж байна.

Товчилсон үг

SO ₂	Хүхэрлэг хий
NO _x	Азотын ислүүд
PM10	Ширхэглэлийн голч нь 10 микрон буюу түүнээс бага хэмжээтэй тоосонцор
PM2.5	Ширхэглэлийн голч нь 2.5 микрон буюу түүнээс бага хэмжээтэй тоосонцор
CO	Нүүрстөрөгчийн дутуу исэл
TSP	Нийт тооцонцор
NMVOС	Метан биш дэгдэмхий органик бохирдуулах бодис
NH ₃	Аммиак

Дүгнэлт

2023 онд Завхан аймгийн хэмжээнд нийт агаар бохирдуулах суурин эх үүсвэр 10753 тоологдож, 92374.5м³ мод, 49273.25тн нүүрс, 153.825тн сайжруулсан түлш, бусад 3059.2 тн түлш зарцуулсан байна.

Томоохон уурын зуухнууд утаа шүүх шүүлтүүргүй, мөн яндангийн өндөр нь стандарт шаардлага хангаагүй нүүрсний дутуу шаталт их хэмжээгээр агаарт цацагдаж орчны бохирдлыг нэмэгдүүлж байна.

Том оврын уурын зуухнуудын нүүрс, үнсний сав ил задгай байгаагийн улмаас салхины нөлөөгөөр их хэмжээний нүүрсний хаягдал гарч орчны болон хөрсний бохирдолыг ихэсгэж байна.

Эдгээр агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн тоо зарим сумдад нэмэгдэх хандлагатай байна. Өмнөх онтой харьцуулан харахад түүхий нүүрсний хэрэглээ багассан байна.

Агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр усан халаалттай 15-100 кВт хүчин чадалтай зуух өмнөх оноос хасагдсан нь Тосонцэнгэлд 7 зуух шинээр нэмж тоологдсон ба Улиастай сумд 8 зуух хасагдсан. Үүний 1 зуух цахилгаан, 1 зуух төвлөрсөн халаалтанд, 2 зуух нэгдэж, 4 зуухны үйл ажиллагаа зогссон. Их уул сумын 9 зуух, Отгон сумын 8 зуух 101-4200кВт төвлөрсөн халаалтанд холбогдсон байна.

Усан халаалтын 15-100 кВт хүртэл чадалтай 70 зуухнаас жилд дунджаар 4866.65тн нүүрс, 523м³ мод хэрэглэсэн байна.

100-4200 кВт хүртэл хүчин чадалтай 44 зуухнаас жилд дунджаар 38842тн нүүрс зарцуулж дулаан үйлдвэрлэсэн байна.

Сумууд нэгдсэн халаалтанд холбогдсон нь сайн талтай боловч зарим сум байршлаа зөв сонгоогүй мөн стандартын шаардлага хангасан зуух тавиагүй, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа Отгон, Дөрвөлжин, Яруу, Тэлмэн сумд гэх зэрэг дутагдал байна.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр аймгийн хэмжээнд 13429 авто тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Өмнөх онтой харьцуулахад тусгай зориулалт, нийтийн тээврийн тоо буурч, бусад төрлийн тээврийн хэрэгслийн тоо өсөлттэй байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ